



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо
байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.1, Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциаци, Сангийн яам хоорондын 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн гэрээ, “Эрчим хүчний төсөл -2”-ын Төслийн удирдах хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03/2020 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн банкны зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд хэрэгжих “Кабелийн гэмтэл тодорхойлох автомашин дээр суурилагдсан лаборатори” нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Ш.Ганзориг

-Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга

Гишүүд:

Э.Мөнхтөр

-Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Ж.Ганбаатар

-“Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Б.Энхзаяа

-“Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төсөл хэрэгжүүлэх албаны дарга

Г.Төрбат

-“Монголын эрчим хүчний ассоциаци” ТББ-ын гишүүн

Ц.Санчин

-“Монголын эрчим хүчний ассоциаци” ТББ-ын гишүүн

170600121

Нарийн бичгийн дарга:
Р.Гэрэлсүрэн

-“Эрчим хүчний төсөл-2” Төсөл хэрэгжүүлэх
нэгжийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний
ажилтан

2.Тендерийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, тендерийн үнэлгээний дүгнэлт гаргаж танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ш.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Б.НАСАНТОГТОХ